



**УЛААНБААТАР ЛИФТ НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

**НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ
ЛИФТИЙГ ОРШИН СУУГЧДЫН
ХӨРӨНГӨӨР ШИНЭЧЛЭХ БОЛОМЖИЙН
ТАЛААРХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

2023

НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ ЛИФТИЙГ ОРШИН СУУГЧДЫН ХӨРӨНГӨӨР ШИНЭЧЛЭХ БОЛОМЖИЙН ТАЛААРХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны зорилго:

Энэхүү судалгааны зорилго нь Нийслэлийн хэмжээнд нийтийн зориулалттай орон сууцны ашиглалтын хугацаа дууссан болон ашиглалтын шаардлага хангахгүй улсын байцаагчийн дүгнэлт гарсан 132 лифтийг оршин суугчдын хөрөнгөөр шинэчлэх боломжийг тодорхойлоход оршино.

Судалгааны зорилт:

Судалгааны зорилгыг хангахын тулд “Улсын төсвийн хөрөнгөөр шинэчлэгдэхийг хүлээхгүйгээр өөрсдийн нөөц бололцоог ашиглан лифтээ шинэчилж, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх” зорилтыг дэвшүүлэв.

Судалгааны түүвэрлэлт, судалгааны хамрах хүрээ:

Дээрх зорилго зорилтуудыг хангахын тулд нийтийн зориулалттай орон сууцны ашиглалтын хугацаа дууссан болон ашиглалтын шаардлага хангахгүй улсын байцаагчийн дүгнэлт гарсан 132 лифтийг ашигладаг 95 өрх, оршин суугчдаас 2023 оны 05 дугаар сарын 03-10-ны өдрүүдэд түүвэрчилсэн аргаар судалгааг авсан.

Судалгааны багийн зүгээс судалгаанд хамрагдах өрх, оршин суугчдыг тодорхойлохдоо лифт ашигладаг буюу 3-аас дээш давхрын өрхийг сонгосон бөгөөд дээрх судалгааны түүвэр нь судалгааны төлөөлөх чадварыг бүрэн хангана гэж үзэж байна.

Үзүүлэлт	Утга	Тайлбар
Түүврийн нэгж	1 хүн	1 өрхөөс 1 санал асуулга
Түүврийн хэмжээ	95	Санамсаргүй түүврийн арга (Лифт ашигладаг өрх, оршин суугчид)
Түүврийн төлөөлөх чадвар		Хангагдсан

Мэдээлэл цуглуулалт:

Мэдээллийг асуулгын буюу анкетын судалгааны аргаар цуглуулсан. Судалгааны анкетыг “Улаанбаатар лифт” НӨҮГ-ын судалгаа авах хэсэг бэлтгэж, үр дүнг нэгтгэв.

Асуулгын бүтэц:


Судалгааны анкет дараах бүтэцтэй болно.

- Судалгаанд оролцогчийн хувийн мэдээлэл;
- Лифт ашиглах шаардлага;
- Оршин суугчдын хөрөнгөөр лифт шинэчлэх боломж;

Судалгааны танилцуулга:

1. Танай гэр бүлийнхэнд лифт ашиглах шаардлага хэр их гардаг вэ? гэсэн асуултад

Нийт судалгаанд оролцогчдын 5% нь буюу 3 хүртэлх давхарт амьдардаг оршин суугчдад лифтний хэрэглээ бага байдаг тул Заримдаа гэсэн хариулт өгсөн байна. Харин ихэнх буюу 95% нь 4-өөс дээш давхарт амьдардаг тул лифт ашиглалт Байнга гэсэн хариултуудыг өгсөн болно.




■ Байнга ■ Заримдаа ■ Шаардлагагүй

2. Улсын төсвөөр лифт шинэчлүүлэх бол та 5-10 жил хүртэлх хугацаагаар хүлээх боломжтой юу? гэсэн асуултад нийт судалгаанд хамрагдсан оролцогчид санал нэгтгэйгээр Үгүй гэсэн байна.



■ Тийм ■ Үгүй

3. Танай лифтийг өөрсдийн буюу оршин суугчдын хөрөнгөөр хувийн хэвшлийн байгууллагатай гэрээ хийн 2-5 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтийг төлөх зарчмаар шинэчлүүлэх бол зөвшөөрөх үү? гэсэн асуултад Улсын болон орон нутгийн төсвөөс нэг удаа санхүүжүүлж, лифт шинэчлэх боломжтой тул өөрсдийн хөрөнгөөр лифт шинэчлэхийг 95% нь эсэргүүцсэн байна.



4. Хувийн Аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ хийж шинэчлүүлбэл аль төлбөрийн нөхцөл илүү тохиромжтой вэ? гэсэн асуултад дараах байдлаар хариулсан байна.



Судалгаанд хамрагдсан иргэдийн санал хүсэлтүүд:

- Лифтийг шинэчлэх нийт зардлын 30-40 хувийг улсын хөрөнгөөр, 10-20 хувийг ААНБайгууллага, СӨХ-доос, үлдсэн хувийг иргэд оршин суугчдын хөрөнгөөр шинэчлэх боломжтой эсэх.
- Сард төлөх мөнгөн дүн хэт өндөр байна иймд багасгах боломж байгаа эсэх.
- Шинэчлэгдсэн лифтүүдийг Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь заалтын дагуу Улс, нийслэлийн төсвөөр шинэчилсэн байж манай байрны лифтийг шинэчлэхдээ биднээс яагаад хөрөнгө мөнгө гаргуулах гээд хуулиа зөрчөөд байна вэ? Бид төлөх боломжгүй.
- Хүн зөөврийн лифтийг улсын хөрөнгөөр яаралтай шинэчилж иргэд оршин суугчдын аюулгүй байдлыг хангах шаардлагатай байна. Баталгаагүй лифтээр зорчиж байгаад осол аваар гарч амь нас эрсэдвэл хэн хариуцах вэ?

Дүгнэлт:

Шинэчлэгдэх шаардлагатай нийтийн зориулалттай орон сууцны 132 лифтний 95 өрх, оршин суугчдаас 2023 оны 05 дугаар сарын 03-10-ны өдрүүдэд түүвэрчилсэн аргаар нийтийн зориулалттай орон сууцны лифтийг оршин суугчдын хөрөнгөөр шинэчлэх боломжийн талаарх судалгааг авсан бөгөөд 12 давхар байрны оршин суугчдын 96% нь татгалзсан, 4% нь зөвшөөрсөн, харин 8, 9 давхар байрны оршин суугчдын 94% нь татгалзсан, 6% нь зөвшөөрсөн хариулт өгсөн байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА

Д.ГАН-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН
ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР
МЕХАНИК ИНЖЕНЕР

Ц.ӨСӨХЖАРГАЛ
Б.БАЙГАЛЬ
Я.БАТБААТАР